

БАТЛАВ.  
БОЛОВСРОЛ, СОЁЛ, ШИНЖЛЭХ  
УХААН, СПОРТЫН САЙД  
Ц.ЦОГЗОЛМАА

БАТЛАВ.  
ХУУЛЬ ЗҮЙ, ДОТООД  
ХЭРГИЙН САЙД  
Ц.НЯМДОРЖ

## СОЁЛЫН ТУХАЙ ХУУЛИЙН ШИНЭЧИЛСЭН НАЙРУУЛГЫН ТӨСЛИЙН ҮЗЭЛ БАРИМТЛАЛ

### Нэг.Хуулийн төсөл боловсруулах болсон үндэслэл, шаардлага

Монгол Улсын Их Хурлаас Соёлын тухай хуулийг 1996 онд баталснаас хойш нийт 14 удаа нэмэлт, өөрчлөлт оруулсан. Одоо хүчин төгөлдөр мөрдөж буй хууль нь Монгол Улсад соёлын үйл ажиллагаа эрхлэх эрх зүйн үндэслэл, соёлын удирдлагын тогтолцоо, соёлын үйл ажиллагаанд оролцогчдын эрх, үүрэг, тэдгээрийн хооронд үүсэх харилцааг зохицуулж байна.

Дэлхий нийтийг хамарсан даяаршлын үйл явцын эрчимтэй нөлөө, үндэстэн дамнасан соёл хоорондын харилцааны идэвхтэй хөгжил, дэлхий дахины болон улс орны нийгэм, улс төр, эдийн засгийн хүрээнд явагдаж буй хурдацтай өөрчлөлт зэрэг олон хүчин зүйлсээс хамаарч Монгол Улсын соёл, урлагийн салбарыг хөгжлийн шинэ шатанд гаргах зорилгоор Соёлын тухай хуулийг шинэчлэх дараахь хууль зүйн болон практик шаардлага үүсэж байна. Үүнд:

#### 1.1.Хууль зүйн үндэслэл, шаардлага

Монгол Улсын Үндсэн хуулийн Долдугаар зүйлийн 1 дэх хэсэгт "Монголын ард түмний түүх, соёлын дурсгалт зүйл, шинжлэх ухаан, оюуны өв төрийн хамгаалалтад байна." гэж, Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.4.7-д "Монгол соёл иргэншлийн аюулгүй байдал нь үндэсний аюулгүй байдлын бүрэлдэхүүн хэсэг байна" гэж, Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалын 1.1.6-д "Үндэсний түүх, хэл, соёл, өв уламжлал, зан заншлаа хадгалж, хамгаалж хөгжүүлэх нь монгол үндэстний оршин тогтнохын үндэс, амин чухал дархлаа мөн." гэж тус тус заасан.

Нэгдсэн Үндэстний Байгууллагын Ерөнхий Асамблейн 70 дугаар чуулганаас 2015 онд баталж, 2016 онд дэлхий нийтээр хэрэгжиж эхэлсэн "Дэлхийн тогтвортой хөгжлийн зорилт"-ын (2015-2030) 36-д ".... соёлын олон янз байдлыг тэмдэглэн, бүх соёл, иргэншил нь тогтвортой хөгжилд хувь нэмэр оруулах, тогтвортой хөгжлийн нөхцөлийг хангах тулгуур хүчин зүйл болохыг хүлээн зөвшөөрч", Монгол Улсын Их Хурлын 2016 оны 19 дүгээр тогтоолоор батлагдсан "Монгол Улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал-2030" баримт бичгийн 2.1.2-т "Монгол Улс нүүдлийн соёл,

аялал жуулчлалын олон улсын төв болох", "Хүүхэд бүрт ... монгол хэл, сэтгэлгээний үндсийг эзэмшүүлэх"-ийг тусгасан.

"Соёлын илэрхийллийн олон төрлийг хамгаалах болон хөхиүлэн дэмжих тухай конвенц"-ын 13 дугаар зүйлд "соёлыг өөрсдийн тогтвортой хөгжлийн бүх шатны бодлогод нэгтгэхийг эрмэлзэх" бөгөөд үндэсний хөгжлийн бодлого, чиглэлийг боловсруулахдаа соёлыг онцгой чухал бүрэлдэхүүн хэсэг болгон авч үзэхийг улс орнуудад үүрэг болгосон. Энэхүү конвенцийн хэрэгжилтийн хүрээнд гарсан ололт амжилтыг 2015, 2018 оны Дэлхийн тайланд задлан шинжилж, 2030 он хүртэлх Тогтвортой хөгжлийн хөтөлбөртэй нягт холбоотой болохыг дахин тэмдэглэн, хөгжлийн төлөөх бүтээлч байдлыг нэмэгдүүлэх, соёлын салбарын хувьсан өөрчлөгдөж буй хэрэгцээнд тохируулан төрийн бодлогыг боловсруулж, хэрэгжүүлэхийг зөвлөсөн.

Монгол Улсын Их Хурлын 2011 оны 10 дугаар тогтоолын хавсралтаар баталсан "Монгол Улсын гадаад бодлогын үзэл баримтлал"-ын 7.28-д "Гадаад сурталчилгаа, олон нийттэй харилцах бодлого нь Монгол Улсын дотоод, гадаад бодлого, ардчилал, шинэчлэлийн үйл явцыг улс түмэнд сурталчлан таниулах, тэдэнд улс орныхоо талаар эерэг ойлголт, сэтгэгдэл төрүүлэх, найрсгаар хандан талархагчдын хүрээг өргөтгөх, иргэд хоорондын харилцаа, харилцан зорчих явдлыг нэмэгдүүлэхэд оршино." гэж заасан.

Монгол Улсын Их Хурлын 2016 оны 45 дугаар тогтоолын хавсралтаар баталсан "Монгол Улсын Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр"-ийн 3.2.42-т "Соёлын тухай хуулийг шинэчлэн баталж, киноны тухай, музейн тухай хуулийг боловсронгуй болгон хэрэгжүүлэх нөхцөлийг бүрдүүлнэ." гэж, мөн Монгол Улсын Их Хурлын 2017 оны 11 дүгээр тогтоолын хавсралтаар баталсан "Хууль тогтоомжийг боловсронгуй болгох үндсэн чиглэл"-ийн 57-д "Соёлын тухай хууль 1996 онд батлагдсанаас хойш шинэчлэгдээгүй бөгөөд уг хуулийн зохицуулалт нь соёл, урлагийн өнөөгийн харилцааг зохицуулах, цаг үеийн шаардлагыг хангахгүй болсон тул хуулийн зохицуулалтыг шинэчилж боловсронгуй болгох"-оор тус тус тусгаж зорилт дэвшүүлсэн.

## 1.2. Практик шаардлага

Соёлын тухай хуулийн зохицуулалтыг Монгол Улсын Үндсэн хуулийн агуулга, үзэл баримтлалд нийцүүлж үндэсний аюулгүй байдлын баталгааг хангах, аль нэг соёлын дарангуйлалд өртөхгүй байх, өөрийн уламжлалт зан заншил, соёлын давтагдашгүй байдал, онцлогийг хадгалан үлдэх, иргэдийн соёлын талаарх мэдээлэл, мэдлэгийг дээшлүүлэх, боловсролын тогтолцоогоор дамжуулан үндэсний бахархал, соёлын өв, уламжлал, ёс заншилаа дээдэлсэн, монголчуудын үнэт зүйлсийн уламжлал, шинэчлэлийг зохистой хослуулсан иргэнийг төлөвшүүлэх шаардлага үүсч байна.

Сүүлийн үед гадаад бодлогын чухал бүрэлдэхүүн болоод буй Soft power буюу зөөлөн хүчний бодлогын цөм болсон соёлын харилцаагаар дамжуулан олон улсад Монгол Улс, монгол хүний эерэг төсөөлөл бий болгоход соёлын бодлогыг тэргүүлэх зорилт болгох, цаашдаа үндэсний урлаг, соёлын дархлааг сайжруулж, дэлхийн хэмжээнд таниулах, түгээх, хүлээн зөвшөөрүүлэх, дэлхийн түвшинд хүргэх, түүний ач холбогдлыг нэмэгдүүлэх, гадаад харилцаа, аялал жуулчлал, оюуны өмч, спорт

зэрэг бусад салбар, үйл ажиллагаатай уялдуулах, чанаржуулах, өргөжүүлэх шаардлага үүсээд байна.

Өнөөдөр дэлхий дахинд хүмүүсийн амьдралын хэв маягт ихээхэн өөрчлөлт орж, аялал жуулчлал хурдтай хөгжин, манай улс олон улсын аялал жуулчлалын идэвхитэй сонирхлын цэг болж байгаа нөхцөлд соёлын аялал жуулчлал, музейн аялал жуулчлалыг идэвхитэй хөгжүүлэх замаар соёлын санхүүжилтийг нэмэгдүүлэх өргөн боломж нээгдэж байна. Соёлын бүтээлч үйлдвэрлэлийг хөгжүүлэх, үндэсний агуулга, бренд үйлдвэрлэлийг зах зээлд нэвтрүүлэх тэргүүлэх чиглэлийг тогтоох, шинэ мэдлэг, шинэ технологи дамжуулах механизм нэвтрүүлэх нь зүйтэй гэж үзэж байна.

Соёлын үйлчилгээг иргэдийн соёлын болон оюуны хэрэгцээг хангах, соён гэгээрүүлэх, соёлын үйл ажиллагаа, үйлчилгээнд иргэдийг идэвхтэй оролцуулах нөхцөлийг бий болгох, /"хүн төвтэй"/ мэдээллийн шинэ технологи нэвтрүүлэх, үндсэн үйлчилгээнд нэгдсэн стандарт, аргачлал нэвтрүүлэх /Тухайлбал: сум, дүүргийн соёлын төвийн үйлчилгээг/, соёл, урлагийн байгууллагын орчин, үйлчилгээг стандарттай болгох хэрэгтэй байна.

Хүн амын төвлөрөл, шилжилтээс хамаарч соёлын үйлчилгээний хүртээмж хот, хөдөөд харилцан адилгүй байна. Орон нутгийн театр, чуулгыг төрөлжүүлэн болон бүсчилэн хөгжүүлэх, Улаанбаатар хотод үйл ажиллагаа явуулж байгаа мэргэжлийн урлагийн байгууллагуудын үйлчилгээг улсын хэмжээнийх болгох, орон нутгийн театр, чуулгын аялан тоглолт хийх, уран бүтээл солилцох, уран бүтээлч сэлгэн ажиллуулах, уран бүтээлчдийг давтан сургах, цаашдаа уран бүтээлчдийг мэргэшүүлэх сургалтын тогтолцоог улам илүү боловсронгуй, бие даасан хэлбэртэй болгох шаардлагатай байна.

Соёл, урлагийн байгууллагуудын өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэхэд соёл, урлагт өмчийн болон санхүүжилтийн олон хэлбэрийг нэвтрүүлэх, мэргэжлийн урлагийн байгууллагуудыг уран бүтээл туурвих, түүнээс олсон нийт орлого нь санхүүжилтийн гол эх үүсвэр болгох нөхцөлийг бүрдүүлэх нь зүйтэй байна.

Соёл, урлагийн ажилтаныг мэргэжил, ур чадвараа дээшлүүлэх, олон улсын түвшинд өрсөлдөх чадварыг нь нэмэгдүүлэх, улмаар тэдний хөдөлмөрийн үр дүнг бодитой, зөв үнэлэх, урамшуулах, шударга өрсөлдөх механизмыг бүрдүүлэх зорилгоор уран бүтээлчдэд мэргэжлийн зэрэг олгох шаардлага бий болсон.

Соёл, урлагийн салбарт шинжлэх ухаан технологи, инновацийн ололтыг нэвтрүүлэх, шинжлэх ухааны үндэслэлтэй судалгаан дээр суурилах, соёл, урлаг, боловсрол, шинжлэх ухааны салбарын нягт хамтын ажиллагааг хангах бодлого, эрх зүйн орчин бүрдүүлэх шаардлага тулгарч байна.

### **Хоёр.Хуулийн төслийн бүтэц, зохицуулах харилцаа, хамрах хүрээ**

Хуулийн төсөл нь Хууль тогтоомжийн тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.1.3 дахь заалтад заасны дагуу хуулийн шинэчилсэн найруулгын төсөл байна.

Хуулийн төсөлд дээр дурдсан практик хэрэгцээ шаардлагад үндэслэн зохицуулах харилцаа, хамрах хүрээг дараахь байдлаар тусгана. Үүнд:

1.Хуулийн нийтлэг үндэслэл болох хэсэгт хуулийн зорилтыг тодорхойлж, соёлын тухай хууль тогтоомж, хамрах хүрээ, соёлын үйл ажиллагаанд баримтлах бодлого, зарчмыг тогтоож, нэр томъёоны тайлбарыг тусгана.

2.Соёлын салбарын удирдлага, зохион байгуулалт, төрийн болон нутгийн өөрөө удирдах ёсны байгууллага, үндэсний зөвлөлийн эрх, үүргийг тодорхойлно.

Мөн соёлын үйл ажиллагаан дахь иргэний болон соёл, урлагийн бус бусад байгууллагын эрх, үүрэг, олон нийтийн түншлэл, оролцоог тодорхойлно.

3.Соёлын үйл ажиллагаа, түүний төрөл, хэлбэр, соёлын үнэт зүйлсийг бүтээх, түгээн дэлгэрүүлэх, ашиглах, судлах, соёл урлагийн боловсрол эзэмших, соёл урлагийн салбар дахь судалгаатай холбогдсон зохицуулалтыг тусгана.

4.Соёл, урлагийн үйлчилгээний нөхцөл, журам, соёл, урлагийн үйлчилгээний стандарт, аргачлалыг тогтоох, соёлын бүтээлч үйлдвэрлэл хөгжүүлэх асуудлыг тусгана.

5.Соёл, урлагийн байгууллагын төрөл, чиг үүрэг, удирдлага, зохион байгуулалт, эрх, үүргийг нарийвчлан хуульчилна.

6.Соёлын үйл ажиллагааны эдийн засаг, санхүүгийн олон төрөлт эх үүсвэр, зарцуулалтын оновчтой, үр дүнтэй үйл ажиллагааг тодорхойлно.

Соёл, урлагийн үйл ажиллагаа, үйлчилгээний санхүүжилт, соёлын үйлчилгээг хүн бүрд хүртээмжтэй, тогтвортой түгээх үүднээс төрөөс үзүүлэх дэмжлэг, хөнгөлөлт, төрийн өмчийн соёл, урлагийн байгууллагаас үзүүлэх төлбөртэй үйлчилгээг тогтоож, төлбөртэй үйлчилгээ үзүүлж олсон орлогыг соёл, урлагийн ажилтны хөдөлмөрлөх нөхцөлийг сайжруулах, нийгмийн баталгааг хангах, техник, тоног төхөөрөмж, худалдан авах, засвар, үйлчилгээ хийхэд зарцуулах нөхцөлийг бий болгоно.

7.Соёл, урлагийн ажилтны эрх, үүрэг, уран бүтээл чөлөөтэй туурвих, шударга өрсөлдөх механизмыг бүрдүүлэх, уран бүтээлчдэд мэргэжлийн зэрэг олгох асуудлыг тусгана.

8.Соёлын өвийг бүртгэх, хадгалах, хамгаалах болон соёл, урлагийн байгууллагын статусын асуудлыг Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн шинэчилсэн найруулгатай, мөн уламжлалт шашин, шүтлэгийн зориулалттай соёлын өвийг бүртгэх, хадгалах, хамгаалах асуудлыг Төр, сүм хийдийн харилцааны тухай хуулийн шинэчилсэн найруулгатай тус тус уялдуулан боловсруулж тусгана.

9.Соёлын үйл ажиллагаан дахь хязгаарлалт, соёлын тухай хууль тогтоомжийн хэрэгжилтэд тавих хяналтын асуудлыг тусгана.

**Гурав.Хуулийн төсөл батлагдсаны дараа үүсч болох нийгэм, эдийн засгийн үр дагавар**

Хууль батлагдан гарснаар үндэсний соёл уламжлалаа дээдлэх, хөгжүүлэх дархлаа бий болж, соёлын үйл ажиллагаан дахь төрийн болон төрийн бус байгууллага, аж ахуйн нэгж, иргэдийн оролцоо нэмэгдэнэ.

Соёлын үйлчилгээ, хүртээмж сайжирч, уран бүтээл хийх сэдэл бий болгох, соёл, урлагийн үйл ажиллагааны санхүүжилт нэмэгдэх, үндэсний соёлыг хадгалах, хамгаалах, судлах, соёлын олон улсын хамтын ажиллагааг дэмжих, соёл урлагийн салбар дахь мэргэжлийн болон шинжлэх ухааны судалгааг нэвтрүүлэх, иргэдийн соёл, урлагийн боловсролыг дээшлүүлэх, шинэ техник, технологи нэвтрүүлэх нөхцөл бүрдэнэ.

Иргэдэд үзүүлэх соёлын үйлчилгээний чанар, хүртээмжийг нэмэгдүүлэх, орон нутгийн театр, чуулгын урын санг үндэстэн, ястны онцлогтой уялдуулан хөгжүүлэх, материаллаг баазыг бэхжүүлэхэд чухал нөлөө үзүүлнэ.

Уран бүтээлийг бодитойгоор урт хугацаанд дэмжих, соёлын харилцаанд оролцогчдын хөдөлмөрийг зүй зохистой үнэлж, хөгжүүлэх нөхцөл бүрдэнэ.

**Дөрөв.Хуулийн төсөл Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын нэгдэн орсон олон улсын гэрээ, бусад хуультай хэрхэн уялдах, уг хуулийг хэрэгжүүлэхтэй холбогдон цаашид шинээр боловсруулах, хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах, хүчингүй болгох хуулийн тухай**

Энэ хуулийн төслийг Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын олон улсын гэрээ, бусад хууль тогтоомжид нийцүүлэн боловсруулна.

Уг хуулийн төслийг дагалдуулан Соёлын өвийг хамгаалах тухай хууль, Номын сангийн тухай хууль, Ашигт малтмалын тухай хууль, Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хууль, Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хууль Засгийн газрын тусгай сангийн тухай хууль болон шаардлагатай бусад хуульд холбогдох өөрчлөлтийг оруулж, Соёлын тухай хууль хүчингүй болсонд тооцох тухай хуулийн төслийг боловсруулна.

---oOo---